

2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН ӨГ СӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

№	Товч агуулга	Биелэлт	Хувь
1	Нийслэл, дүүргийн 2017 оны батлагдсан төсвийг ил тод болгон сурталчилах, төсвийн жилийг эхлүүлэх бэлтгэлийг хангах хүрээнд нийслэлийн хэмжээнд Худалдан авах ажиллагааны үзэсгэлэн зохион байгуулах, 2017 онд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтаар хийгдэх ажлуудын графикийг гаргаж, сар сард хийх ажлуудыг олон нийтэд мэдээлэх, зар хүргэх ажлуудыг зохион байгуулах./ Санхүү, төрийн сангийн хэлтэс, Бодлого, төлөвлөлтийн хэлтэс/		-
2	Нийслэлийн 2017 оны төсөв батлагдсантай холбогдуулан Дүүргүүдийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 2017 оны төсвөө 2016 оны 12 дугаар сарын 20-ны дотор багтаан хэлэлцүүлэх./ Дүүргийн ЗДТГазар/		-
3	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд 2016 онд хийж хэрэгжүүлсэн ажлаа дүгнэх, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй уялдуулж ирэх онд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулах.	2016 оны Үр дүнгийн гэрээг жилийн эцсийн байдлаар хэлтсүүдээс албан хаагч тус бүрээр нь тайлан хурааж авлаа. 2016 онд хийж хэрэгжүүлсэн ажлын дэлгэрэнгүй тайланг нэгтгэж байна.	-
4	Шинэ жилийн болон баяр ёслол арга хэмжээг зохион байгуулахдаа төсвийн хөрөнгө зарцуулахгүй байх тухай Засгийн газрын 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааны 58 дугаар тэмдэглэлийн заалтыг хэрэгжүүлж ажиллах. / Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд/	Засгийн газрын 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааны 58 дугаар тэмдэглэлийн заалтын дагуу төсвийн хөрөнгөөр шинэ жил тэмдэглэхгүй болно.	-
5	Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтын нэгдсэн график гаргах, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдыг сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулах. / Нийслэлийн Онцгой байдлын газар/		-
6	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, саналын шийдвэрлэлтэд хариу өгч байгаа арга барил, хандлагад эерэг өөрчлөлт гаргах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулах. / Төрийн захиргаа удирдлагын хэлтэс, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд/	2016 оны 5-наас 13-ны хооронд иргэдээс өргөдөл гомдол ирээгүй. Байгуулгын хэмжээнд ирсэн өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж Smartcity програмд бүртгэлжүүлсэн.	-
7	Санхүү, төрийн сангийн хэлтэст боловсруулж байгаа сайд нартай байгуулах гэрээний төсөлд агентлагууд санал өгөх. Нийслэлийн Засаг дарга Салбарын сайд нартай байгуулах гэрээний төсөлд хамтарч хийх ажлуудын хөрөнгө, санхүүг тодорхой тусгаж холбогдох яамдуудад хүргүүлэх. / Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд/		-
8	Баянгол дүүрэгт нийслэлийн Хүүхдийн эмнэлэг байгуулах тухай шийдвэрийн төсөл боловсруулж танилцуулах. / Эрүүл мэндийн газар, Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын/		-
9	Дүүргүүдийн нэгдсэн эмнэлэгийн менежментийн асуудлаар танилцуулага бэлтгэж нийслэлийн Засаг даргад танилцуулах. / Нийслэлийн Эрүүл мэндийн газар/		-

ХЯНАСАН:
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН АХЛАХ

Ц.ИЧИНХОРЛОО

НЭГТГЭСЭН:
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Э.ГЭРЭЛМАА